| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,080,600.00 | 1,068,000.00 | 8,012,600.00 | 11.76 |
| 26 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 6,432,143.00 | (6,432,143.00) | - |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 6,432,143.00 | (6,432,143.00) | - |
| 81102 - Орон нутгийн нөөц хөрөнгө | | 7,500,000.00 | 25,000,000.00 | (17,500,000.00) | 333.33 |
| 12 | Татварын бус орлого | 15,000,000.00 | 25,000,000.00 | (10,000,000.00) | 166.66 |
| 122 | Тусламж, санхүүжилтийн орлого | 7,500,000.00 | 25,000,000.00 | (17,500,000.00) | 333.33 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 7,500,000.00 | 25,000,000.00 | (17,500,000.00) | 333.33 |
| 123 | Татаас санхүүжилтийн орлого | 7,500,000.00 | - | 7,500,000.00 | - |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 7,500,000.00 | - | 7,500,000.00 | - |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 7,500,000.00 | 25,000,000.00 | (17,500,000.00) | 333.33 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 7,500,000.00 | 25,000,000.00 | (17,500,000.00) | 333.33 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 7,500,000.00 | 25,000,000.00 | (17,500,000.00) | 333.33 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,500,000.00 | 25,000,000.00 | (17,500,000.00) | 333.33 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,500,000.00 | 25,000,000.00 | (17,500,000.00) | 333.33 |
| 82212 - Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ | | 4,998,000.00 | 10,000,000.00 | (5,002,000.00) | 200.08 |
| 12 | Татварын бус орлого | 1,666,000.00 | 9,583,500.00 | (7,917,500.00) | 575.24 |
| 122 | Тусламж, санхүүжилтийн орлого | 1,666,000.00 | 9,583,500.00 | (7,917,500.00) | 575.24 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 1,666,000.00 | 9,583,500.00 | (7,917,500.00) | 575.24 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 4,998,000.00 | 10,000,000.00 | (5,002,000.00) | 200.08 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,998,000.00 | 8,777,830.00 | (3,779,830.00) | 175.62 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,998,000.00 | 8,777,830.00 | (3,779,830.00) | 175.62 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | - | 8,777,830.00 | (8,777,830.00) | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мөргөчдийн | - | 8,777,830.00 | (8,777,830.00) | - |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний | 4,998,000.00 | - | 4,998,000.00 | - |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,998,000.00 | - | 4,998,000.00 | - |
| 26 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,222,170.00 | (1,222,170.00) | - |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 1,222,170.00 | (1,222,170.00) | - |
| 12000 - Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | | (0.00) | | |

Нарийнтээл сумын ЗДТГ-ын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлан он |
|--|---|----------|----------------------|
| 11000 - Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл | | - | - |
| 00000 - Төрийн сан | | - | 516,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 516,000.00 |
| 26 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 516,000.00 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 516,000.00 |
| 70106 - Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага | | - | 96,149,353.00 |
| 80101 - Үндсэн үйл ажиллагааны зардал | | - | 26,610,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 26,610,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 22,380,000.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 22,380,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | - | 18,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | 18,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнийн төлбөр, хураамж | - | 3,000,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 1,380,000.00 |
| 26 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 4,230,000.00 |
| 261090 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 4,230,000.00 |
| 13 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | - | 27,308,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 27,308,000.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан | - | 182,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн | - | 500,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны | - | 25,854,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт | - | 772,000.00 |
| 80802 - Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | | - | 1,912,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 1,912,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 1,912,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн | - | 1,912,000.00 |
| 80910 - Тээврийн хэрэгсэл | | - | 46,500,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 46,500,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 46,500,000.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | - | 46,500,000.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн | - | 46,500,000.00 |
| 81507 - Мал тооллого | | - | 839,153.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 839,153.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 839,153.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн | - | 839,153.00 |
| 81517 - Статистикийн бусад тооллого, судалгаа | | - | 182,000.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 182,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 182,000.00 |
| 82502 - Мал эмнэлгийн үйлчилгээ | | - | 20,106,200.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | - | 20,106,200.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | - | 20,106,200.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн | - | 20,106,200.00 |
| 12000 - Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | - | - |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нарийнтээл сумын ЗДТГазрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2022.02.23-наас 2022.02.25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.02.25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.02.22-ны өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус байгууллага нь “Хууль тогтоомж, төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн сумынхаа хөгжил цэцэглэлтийн төлөө сэтгэл зүрхээ зориулан ажиллаж, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх, шадар туслагч нь байхад оршино.” гэсэн эрхэм зорилготой.

ЗДТГ-ын даргын тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын нэгж, 5 хүний бүрэлдэхүүнтэй ёс зүйн хороо, өмч хамгаалах байнгын комисс 5 бүрэлдэхүүнтэй төлөвлөгөө боловсруулан байгууллагын өмч хөрөнгийн хөдлөл өөрчлөлт, бараа материалын худалдан авалтад тухай бүр хяналт тавьж ажилладаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Нарийнтээл сумын ЗДТГазрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нарийнтээл сумын ЗДТГазрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 648.0 сая төгрөгөөс 1 хувиар буюу 6.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 4.5 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Нарийнтээл сумын ЗДТГазрын 2021 оны үндсэн хөрөнгийн тодруулга тайлангаар 331.2 сая төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэлд тусгаснаас 56.7 сая төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 274.5 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсан байна. Тайлант онд 93.3 сая төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг акталжээ.

Бараа материалын тодруулга тайлангаар 21.9 сая төгрөгийн бараа материалыг төсвийн хөрөнгөөр худалдан авч орлогоор бүртгэж, 17.6 сая төгрөгийн зарцуулалт хийжээ.

Тайлант онд 3.6 сая төгрөгийн өглөг, 0.4 сая төгрөгийн авлагыг тодруулга тайланд толилуулжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн хүрээнд 23.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан орон нутгийн төсвөөс 457.4 сая төгрөгийн санхүүжилт, өөрийн орлогоор 1.7 сая төгрөгийг орлого бүрдүүлж, 433.7 сая төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулжээ.

Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар 96.7 сая төгрөгийн санхүүжилт авч 0.8 сая төгрөгийг мал тооллогын ажилд, 20.1 сая төгрөгийг мал эмнэлгийн үйлчилгээнд, 46.5 сая төгрөгийг авто машин худалдан авахад, 24.6 сая төгрөгийг бараа үйлчилгээний зардалд зарцуулж 4.7 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах дараах зүйл байна.

-Тайлант онд үндсэн үйл ажиллагаа, болон нэмэлт санхүүжилтээс ковид-19-тэй холбоотой 7.1 сая төгрөгийг зарцуулсан байна.

3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 5 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Нарийнтээл сумын ЗДТГазар нь 2021 оны 4 дүгээр улиралд нийт 237.7 сая төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 153.2 сая төгрөгийн 141 мэдээллийг ил тод мэдээлж 8 мэдээллийг мэдээлээгүй, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 84.5 сая төгрөгийн зарлагын 6 гүйлгээг мэдээлээгүй, 28 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Иймд дээрх зөрчлийг арилгуулах, давтан гаргахгүй байх, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлагыг сумын Засаг даргад хүргүүллээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар бараа материалын тайлан гаргаагүй, жолоочийн тооцоо бодсон акт үйлдээгүй, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлээгүй, анхан шатны баримтын бүрдүүлэлт хангалтгүй зэрэг 896.3 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн. Албан шаардлага, актын биелэлтийг 2021.05.25-ны №2/147 дугаар бүхийн албан бичгээр нотлох баримтын хамт ирүүлсэн байна.

3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөлтийн шатанд 5.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн. Аудитаар үр өгөөж бүртгээгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 55.4 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүллээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

4.2 Зөвлөмж

Аудитаар зөвлөмж гараагүй.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

(сая төгрөгөөр)

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|-----|-------------------------------------|----------------------|------|-----------|-----|---------------|-----|-----------------|------|---------|-----|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Баян-Өндөр сумын ЗДТГ | 3 | 55.4 | | | | | 3 | 55.4 | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР  Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АХЛАХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

2022 ОНЫ 02 ДУГААР САРЫН 25-НЫ ӨДӨР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 18А-2022/34/НА-СТА-ТДЗ/А 158 0349/17/ Арвайхээр

НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА
Б.СУГАР ТАНАА

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нарийнтээл сумын ЗДТГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны сайтад 28 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 84486.4 мянган төгрөгийн зарлагын 6 гүйлгээг мэдээлээгүй байгаа нь өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан, шатахуун зарцуулалтын анхан шатны баримтуудаа үрэгдүүлсэн зэрэг зөрчлүүд байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1.3.тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх; 6.4.5 дахь "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" сайтад мэдээлнэ:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1."Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." 13.4."Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна." гэсэн заалтууд эдгээрт нийцүүлэн гаргасан тогтоол, шийдвэрүүдээр батлагдсан журам, дүрмүүдийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтанямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэсэн заалтыг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нарийнтээл сумын ЗДТГазрын холбогдох албан тушаалтнуудад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт албан ёсоор ирүүлэхийг сумын Засаг дарга Б.Сугарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТАГ-ЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
О.БАТЖАРГАЛ
Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 08А-2022/34/НА-СТА-ТӨУС/11580349/172
Арвайхээр

НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА Б.ИЧИННОРОВ ТАНАА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд шатахуунд 20861.1 мянган төгрөгийг зарцуулсан боловч 8984.9 мянган төгрөгийн зарцуулалтын анхан шатны нотлох баримт нь байхгүй байна. /Баримтаа алга болгосон/ зөрчил илэрлээ.

Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13.1"Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." 13.4."Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна" гэсэн заалтуудын мөрдөж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээр дурдсан алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, нотлох баримтын бүрдүүлэлтийг хангаж, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан тухай биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 30-ны дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нарийнтээл сумын ЗДТГ-аар дарга Б.Ичинноров, нягтлан бодогч Г.Пүрэвдавга нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ө.БАТЖАРГАЛ
АХЛАХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 сарын 25 өдөр

Дугаар НА-2022/34/НА-СТН-ТУБ/А1382349/173 Арвайхээр

НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗДТГ-ЫН
ДАРГА Б.ИЧИННОРОВ ТАНАА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 46500.0 мянган төгрөгөөр авто машин худалдан авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2 батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;


Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.4-д "... автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх, талаар байгууллага албан тушаалтанд албан шаардлага өгнө." Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11-д заасан "хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дээр дурдсан зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан тухай биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 01-ний дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Нарийнтээл сумын ЗДТГазрын дарга Б.Ичинноров, нягтлан бодогч Г.Пүрэвдавга нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  О.БАТЖАРГАЛ
АХЛАХ АУДИТОР  Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ

Зууцаах

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн бүртгэлийн маяг
 Санхүүгийн тайлангийн аудит
 Аудитын код: ЭВА-2022/34/НА-СТА-ТШЗ
 Байгууллагын нэр: Нарийнтээл сумын ЗДТГ

| № | Ажил гүйцэтгэний анги, дансны үлдэгдэл, тодруулга | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн /сая/ | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагдач байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн харуу, тайлбар | Гаргасан шийдэл | Шалгагдагч байгууллагын | |
|---|---|--|------------------|---------------------------------------|---------------------------------------|--|--|-------------------------|-----------------------------|
| | | | | | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | Шилэн данс төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй байгаа нь өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна. | Шилэн дансны сайтэд 28 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй 84486.4 мянган төгрөгийн 6 гүйлгээг мэдээлээгүй байгаа нь өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан байна. | 0 | Албан шаардлага өгөх | Санал байхгүй. | Төрийн аудитын тухай хуулийн 42.1.Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно. | Өмнөх оны аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, Шилэн данстай холбоотой зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцуулах албан шаардлагыг хэргүүлж байна. | Дарга, Нягтлан бодогч | Б.Ичинноров Г.Пүрэвдавга |
| 2 | Нийт зардал | Тайлант онд 46500.0 мянган төгрөгөөр авто машин худалдан авсан. | 46.5 | Албан шаардлага өгөх | Санал байхгүй. | Төсвийн тухай хуулийн 16.5.2.Батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих; Засгийн газрын 43 дугаар тогтоолын 1.4-д "... автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх", | Зөрчлийн давтан гаргахгүй байж, хууль журмыг хэрэгжүүлж ажиллах | Дарга, Нягтлан бодогч | Б.Ичинноров Г.Пүрэвдавга |
| 3 | Нийт зардал | Шатахуунд 20861.1 мянган төгрөгийг зарцуулсан боловч 8984.9 мянган төгрөгийн зарцуулалтын анхан шатны нотлох баримт нь байхгүй байна. /Баримтаа алга болгосон/ | 8.9 | Албан шаардлага өгөх | Санал байхгүй. | НББ-ийн тухай хуулийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтөлх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно. 13.4.Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна. | Нотлох баримтын бүрдүүлэлтийг хангаагүй тул албан шаардлага хүргүүлсэн. | Дарга, Нягтлан бодогч | Б.Ичинноров Г.Пүрэвдавга |



Бэлтгэсэн: АХЛАХ АУДИТОР
 Анхан шатанд хянасан: АУДИТЫН МЕНЕЖЕР
 Хоёр дахь шатанд хянасан: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Танилцаж зөвшөөрсөн: НАРИЙНТЭЭЛ СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА
 НИЯГЛАН БОДОГЧ

Б.ЭРДЭНЭЦЭГ
 Д.ГАНСУХ
 О.БАТЖАРГАЛ